

Мэдээллийг найдвартай солилцох нь аюулгүй үйл ажиллагааны үндэс юм.

2022 оны 10 сар



Зураг 1. Усны тоолуурыг тохируулахын өмнө

Шатамхай бодис тогтмол дамжуулах үйлдэл бүхий үйлдвэрлэлийн процессыг нэгэн туршлага багатай оператор ажиллуулж байсан. Ажлын явцад засварын ажилтан усны тоолуур салган авч, засварын цехэд тохиргоо хийх шаардлагатай байсан тул процессын нэг хэсгийг унтраасан ба бусад хэсгийн үйл ажиллагаа нь хэвийн үргэлжилсэн. Засварчин тоолуурыг буцааж угсарсны дараа талбайг орхиж явсан. Оператор тоолуурыг ажиллагаанд бэлэн болсон хэмээн тооцоолж, бодис дамжуулах процессыг дахин эхлүүлсэн. Гэвч нэг фланец дутуу чангалагдсан байсны улмаас бодис цацагдаж, операторыг шүршсэн. Оператор аюулгүйн шүршүүрийг ашигласан бөгөөд түүнд ямар нэгэн гэмтэл учраагүй. Бодисын асгаралтыг аюулгүйгээр цэвэрлэсэн.

Дээрх тохиолдлын шалтгаан юу вэ? Үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаанд бидний мөрддөг арга барилуудын олонх нь энд огт ашиглагддаггүй байсан. Түгжих-Пайзлах ажиллагаа маш албан бус буюу зөвхөн пайз эсвэл цоож болон пайз ашигладаг байсан. Засварын ажил гүйцэтгэхтэй холбоотой “ажлын зөвшөөрөл олгох” эсвэл мэдээлэл солилцох өөр ямар нэгэн албан ёсны арга хэрэгсэл байгаагүй.

Нарийн судалгаанаас харахад оператор процессыг дахин үргэлжлүүлэх гэж хэт яарсан учир ажлын гүйцэтгэлийг нягтлан шалгаагүй байж болзошгүй. Магадгүй засварчин дахин нэг жийргэвч хэрэгтэй болсон бөгөөд тэрбээр ажлын гүйцэтгэлийн талаар операторт ямар ч мэдээлэл өгөлгүйгээр талбайг орхиж явсан. Бодисын тусгаарлалтын хавхлага дээр пайз байрлуулаагүй байсан нь “засварын ажил дууссан” гэж ойлгоход хүргэсэн.

Та мэдэх үү?

- Бидний ашигладаг аюулгүй ажиллагааны системүүдийн олонх нь өнгөрсөн хугацаанд тохиолдож байсан ослуудын сургамжаас үүдэлтэй байдаг. Тэдгээрийн зорилго бол тэрхүү алдаануудыг дахин давтагдахаас сэргийлэх юм.
- Мэдээллийг найдвартай солилцох, ойлголцох нь ямагт чухал байдаг. Ялангуяа олон баг хамтран ажиллаж байгаа үед энэ нь нэн чухал зүйл юм. Оролцох багийн тоо нэмэгдэх тусам мэдээлэл солилцох албан ёсны арга хэрэгсэл ашиглах хэрэгцээ улам өсдөг.
- Олон компани аливаа ажлыг гүйцэтгэхийн өмнө, гүйцэтгэх явцад болон гүйцэтгэсний дараа мэдээллийг найдвартай солилцож, баталгаажуулахын тулд “ажлын зөвшөөрөл олгох” системийг ашигладаг. Үүнд ихэвчлэн аюулыг хянах, ажлын талбайг шалгах, эрх бүхий ажилтны зөвшөөрөл авах зэрэг алхмууд багтдаг.
- Ажлын зөвшөөрөл нь ердөө албан ёсны журам төдий зүйл биш бөгөөд ажлын хамрах хүрээг оновчтой тодорхойлсон эсэх, ажлын багууд бүгд юу хийх ёстойгоо мэдэж байгаа эсэх, бусад нэмэлт зөвшөөрлүүдийг (Түгжих ба Пайзлах, Өндөр Хэмийн Ажил, Хязгаарлагдмал Орчин гэх мэт) зохих ёсны дагуу ашиглаж байгаа эсэх зэргийг баталгаажуулдаг хэрэгсэл юм. Мөн бүх ажлыг бүрэн гүйцэтгэж дууссан буюу ажлыг цааш үргэлжлүүлэхэд бэлэн эсэхийг бататгах арга зам болдог.
- Ажил үргэлжлэх явцад тухайн ажлын хамрах хүрээ өөрчлөгдөж болно. Ажлын багуудын хувьд аливаа өөрчлөлтүүдийн талаарх мэдээллийг хоорондоо солилцож, тухайн ажлыг үргэлжлүүлэхэд аюулгүй эсэхийг үнэлэх нь маш чухал. Тиймээс тодорхой дүгнэлт хийгдэх, шинэчилсэн ажлын төлөвлөгөө боловсруулагдах, зөвшөөрөгдөх хүртэл тухайн ажлыг түр зогсоох шаардлагатай болж ч болзошгүй юм.

Та юу хийж болох вэ?

- Танай компанид “ажлын зөвшөөрөл олгох” тогтолцоо хэрхэн хэрэгждэг талаар сайн мэддэг байх хэрэгтэй.
- Ажлын зөвшөөрөл шаардлагатай ажлуудад аюулын үнэлгээ хийхэд идэвхтэй оролц. Магадгүй үнэлгээний багт ямар нэгэн нөхцөл байдал эсвэл аюулын талаар мэддэг цорын ганц хүн нь та байж ч болзошгүй.
- Таны ажлын талбайд хийгддэг хэвийн бус ажлуудын тухай, тэрхүү ажлуудад таны гүйцэтгэх ёстой үүрэг болон хэвийн үйл ажиллагаанд шилжүүлэхийн тулд юу хийх шаардлагатайг мэддэг байх хэрэгтэй.
- Процессыг дахин эхлүүлэхдээ ажлын төлөвлөгөөг мөрд. Хэрэв ямар нэгэн зүйл буруу бол ажлыг зогсоож, асууж тодруул. Бага хэмжээний саатал учрах нь осол эсвэл осолд дөхсөн тохиолдлоос хавьгүй дээр.
- Үйл ажиллагааг аюулгүй үргэлжлүүлэхийн тулд аливаа ажлын дараа талбайд үлдсэн хог хаягдлыг цэвэрлэ. Үйлдвэрлэлийн материал, төмрийн хаягдлыг зохих зааврын дагуу хаях шаардлагатай.

Засвар үйлчилгээний дараа тоног төхөөрөмжийг ажиллуулахад бэлэн болсон эсэхийг мэдэхгүй бол ЛАВЛАЖ АСУУ!!